

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ  
2020 ОНЫ 02 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГААС**

№	Хийсэн ажил /чиглэлээр/	Гүйцэтгэсэн ажлын төрөл дараах 4-ийн аль нэгийг сонгож (✓) тэмдэглэгээ хийх			
		Тулгамдсан болон хоцорч буй ажил	УИХ, ЗГ-т өргөн барьсан	Салбарын хүрээнд хийгдсэн	Шинэлэг ажил
<b>I. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр</b>					
1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл дээр Ажлын хэсэг ажиллаж байна.			✓	
2	Азийн хөгжлийн банкны зөвлөхүүдээс Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хуулийн төслийн 4 дүгээр хувилбарыг авч ажлын хэсгийн гишүүдэд санал авахаар хүргүүлэв.			✓	
3	Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар "Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг хэрэгжүүлэх журам", "Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэрэгжүүлэх журам"-ыг тус тус хэлэлцүүлж Засгийн газрын 50 дугаар тогтоолоор батлуулав.		✓		
4	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх "Нийгмийн даатгалын болон тэтгэврийн тогтолцооны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, шинэчлэлийн зорилтууд" мэдээллийг бэлтгэв.		✓		
5	Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн Удирдлагын тохиролцооны саналыг БНЧУ-ын талд хүргүүлэв.			✓	
6	Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол улсад суугаа онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдад коронавирус гарсантай холбогдуулан хэлэлцээ хийх хугацааг хойшлуулах албан бичиг хүргүүлэв.			✓	
7	Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар "Үнэт цаас гаргах тухай" тогтоолыг хэлэлцүүлж Засгийн газрын 49 дүгээр тогтоолоор батлуулав.		✓		
8	"Нийгмийн халамжийн үйлчилгээ, арга хэмжээг цахимжуулах талаар авах арга хэмжээний тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын болон Сангийн сайдын хамтарсан тушаалын төсөл боловсруулан батлуулав. Тус тушаалын хэрэгжилтийг хангахтай холбоотой тушаал, шийдвэрийн төслүүдийг боловсруулан батлууллаа.			✓	
9	Орлогыг орлуулан тооцох аргачлалд шинэ хувьсагч үзүүлэлт оруулах бусад шаардлагатай тооцоо судалгааг хийх дэд ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Төрийн нарийн бичгийн даргын тушаалын төсөл боловсруулан батлууллаа.			✓	
10	"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2021 оны үндсэн чиглэл"-д Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр тусгах саналыг нэгтгэн боловсруулав.			✓	
11	2019 оны 275 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-тай холбогдуулан Сангийн яам,			✓	

	Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн саналыг судлан үзэж төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалтад холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулах тогтоолын төслийг боловсруулав.				
12	УИХ-аар хэлэлцэж байгаа “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг Засгийн газраас өргөн барьсан хуулийн төсөл, одоо мөрдөж байгаа Хөдөлмөрийн тухай хууль, олон улсын гэрээ, конвенци, бусад улс орны хөдөлмөрийн харилцааны чиглэлээрх хууль тогтоомжтой харьцуулах ажлыг УИХ-ын даргын 2018 оны 88 дугаар захирамжаар “Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, дагалдах бусад хуулийн төсөл”-ийг УИХ-ын чуулганаар болон байнгын хорооны хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэх, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн даргаас өгсөн чиглэлийн дагуу гүйцэтгэж байна.			✓	
13	Салбарын хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийн талаар судалгаа хийх, чиг үүрэг дахин хуваарилах чиглэлээр хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /ХНХЯ-ны хуулийн хэлтсийн дарга/-аар ажилласан. Ажлын хэсгээс 6 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, төвлөрлийг сааруулах төслийн нэгжид явцын тайланг хүргүүлсэн. Үүнд: 1. Ажлын хэсгийн гишүүдэд чиг үүргийн судалгаа, тайланг танилцуулсан. 2. Ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргасан. 3. Ажлын хэсгийн гишүүдээс ирүүлсэн хуулийн төслийн саналыг эцэслэн томъёолсон. 4. Газрын дарга нарт судалгаа, хуулийн төслийг танилцуулсан. 5. Төслийн нэгжид явцын тайлан, мэдээлэл хүргүүлсэн.	✓			
<b>II. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр</b>					
14	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний 5 дахь хөтөлбөрийн хэрэгжилтийг 2019 оны жилийн эцсийн байдлаар гарган ХШҮДАГ-т хүргүүлсэн. Мөн Зам тээврийн салбарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг зохион байгуулах ажлын удирдамж, төлөвлөгөөний төслийг боловсруулан ажиллаж байна.			✓	
15	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний тав дахь хөтөлбөрийн 1.1 дэх үйл ажиллагаанд тусгагдсаны дагуу ажилтнуудыг асбесттай холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлж хамгаалахын тулд Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын Үндэсний холбоотой хамтран “Асбесттай харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны зөвлөмж”-ийн төслийг боловсруулж, ХАБЭА-ын Үндэсний хорооны 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлээ.			✓	
16	“Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл” олгох үлгэрчилсэн жагсаалтыг шинэчлэх асуудал ХАБЭА-ын Үндэсний хорооны 2019 оны төлөвлөгөө болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний тав дахь хөтөлбөрийн 1.1 дэх үйл ажиллагаанд тусгагдсан. Энэ хүрээнд “Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл” олгох зөвлөмжийн төсөлд тусгахаар холбогдох байгууллагаас ирүүлсэн саналуудыг нэгтгэлээ.			✓	
17	Засгийн газрын 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөг, “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг олгох журам”-ыг шинэчлэн батлуулав.		✓		

	Засгийн газрын 2020 оны 44 дүгээр тогтоолыг Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлагуудад цахим хэлбэрээр хүргүүлж ХНХЯ-ны <a href="http://www.mlsp.gov.mn">www.mlsp.gov.mn</a> сайтад байршуулав.				
18	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангах ажлын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсрол сургалтын 2.5 жилийн ангид шинэ агуулга нэвтрүүлж байгаа тул уг хичээлийг заах сургагч багш бэлтгэх ажлыг БСШУС-ын яамтай хамтран хийж МБСБ-ын 13 багшийг үндэсний сургагч, нийт 45 багшийг уг хичээл заах багшаар бэлтгэж “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг 1 болон 2-р ангийн суралцагчдад 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн судлахаар бэлтгэл ажлыг бүрэн хангав.			✓	
19	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.26-д туссан “Ахмад настны төрөлжсөн асрамжийн шинэчлэлийн хөтөлбөр” батлах тухай ЗГ-ын тогтоолын төслийг танилцуулгын хамт боловсруулан 2020.02.12-ны өдрийн 1/465 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.		✓		